234

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
УЛСЫН ЯЛЛАГЧИЙН ЭСЭРГҮҮЦЭЛ

2026 оны 03 сарын 19 өдөр Дугаар 15. Есөнбулаг сум

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН
ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНД

Магадлалыг хүчингүй болгуулах тухай

Говь-Алтай аймгийн прокурорын газрын хяналтын прокурор Ө.Манзушир би эрүүгийн 2416001240108 дугаартай шүүгдэгч П.Ундрах, П.Тэгшжаргал нарт холбогдох хэрэгт прокурорын яллах дүгнэлт үйлдэн, 2025 оны 06 дугаар сарын 11-ний өдөр 120 дугаартай прокурорын яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд шилжүүлсэн.

Говь-Алтай аймаг дахь Сум дундын анхан шатны шүүх 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 2026/ШЦТ/63 дугаартай шийтгэх тогтоолоор Шүүгдэгч Олхонууд овогт Пүрэвийн Ундрахыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1, 3, 3.2 дугаар зүйлийн 1, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, зориуд хэрэгжүүлэлгүйгээр бусдад давуу байдал бий болгох гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон" гэм буруутайд,

Шүүгдэгч Олхонууд овогт Пүрэвийн Тэгшжаргалыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1, 3, 3.4 дүгээр зүйлийн 1, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, зориуд хэрэгжүүлэлгүйгээр бусдад давуу байдлыг бий болгох гэмт хэргийг үйлдэхэд хатгагчаар оролцож өөртөө давуу байдал бий болгосон гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1, 3, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч П.Ундрахыг нийтийн албанд томилогдох эрхийг 3 (гурав) жилийн хугацаагаар хасаж, 10,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр буюу 10,000,000 (арван сая) төгрөгөөр торгох ялаар,

-Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.1 дүгээр зүйлийн 1, 3, 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч П. Тэгшжаргалыг нийтийн албанд томилогдох эрхийг 3 (гурав) жилийн хугацаагаар хасаж, 10,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр буюу 10,000,000 (арван сая) төгрөгөөр торгох ялаар тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч П.Ундрах, П.Тэгшжаргал нарт оногдуулсан торгох ялыг шийтгэх тогтоол хүчин

төгөлдөр болсон өдрөөс хойш 1 (нэг) жил, 6 (зургаа) сарын хугацаанд тус тус хэсэгчлэн төлүүлэхээр тогтоож шийдвэрлэсэн бөгөөд энэ шүүх хуралдаанаар шинжлэн судалсан нотлох баримтуудыг үнэлж дүгнэн үндэслэл бүхий шийдвэр гаргажээ.

Харин Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2026 оны 07 сарын 06-ны өдрийн 2026/ДШМ/17 дугаартай магадлалаар Говь-Алтай аймгийн анхан шатны шүүхийн 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 2026/ШЦТ/63 дугаартай шийтгэх тогтоолыг хүчингүй болгож Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын дарга П.Ундрах Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг дарга Г.Болормаагаар 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/70 дугаартай "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжийг батлуулан үнэлгээний хороог шинээр байгуулан энэ талаар үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Н.Цэвэлмаа, гишүүн А.Сарантуяа, А. Нансалмаа нарт мэдэгдэлгүйгээр албан ажлаар Тайшир суманд явж байх үед нь үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулж тендер сонгон шалгаруулалтад материал ирүүлсэн өөрийн төрсөн дүү болох П. Тэгшжаргалын хамаарал бүхий "Олон улаач" ХХК-ийг шалгаруулсны дараа 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ГААТАХТУНАГ22/10 дугаартай гэрээг байгуулж, техникийн стандарт үзүүлэлтэд нийцээгүй, өөрийн нөхөр болох Г.Дагвадоржийн нэр дээр итгэмжлэлтэй байсан 19,300,000 төгрөгийн үнэ бүхий автомашиныг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Тайшир сумын Засаг даргын Тамгын газарт нийлүүлж өөртөө болон бусдад эдийн засгийн давуу байдал бий болгосон, тус аймгийн Тайшир сумын Орон нутгийн хөгжлийн санд 10,660,000 төгрөгийн хохирол учруулсан гэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож,

шүүгдэгч П.Тэгшжаргал Говь-Алтай аймгийн Тайшир сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хог тээврийн унаа нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг Сонгон шалгаруулах ГААТАСЗДТГ/202201007 дугаартай тендер шалгаруулалтад "Олон Улаач" ХХК-ийн нэрийг ашиглан тендер сонгон шалгаруулалтад оролцон шалгарах үйл явцад төрсөн эгч болох Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын дарга П.Ундрах шийдвэр гарган нөлөөлсөн түүнд давуу байдал олгосон нөхцөл байдал хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдоогүй ба тендерийн шаардлагад нийцсэн автомашин нийлүүлсэн асуудал нь гэмт хэргийн шинжгүй байна. П.Ундрах нь үнэлгээний хорооны гишүүнээр томилогдсон байхдаа "Олон Улаач" ХХК-ийг тухайн тендерт шалгаруулахаас татгалзсан баримт хэрэгт авагджээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д заасан " гэмт хэргийн шинжгүй" үндэслэлээр анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, шүүгдэгч П.Ундрах, П.Тэгшжаргал нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж шийдвэрлэжээ.

Магадлалыг 2026 оны 08 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авч танилцаад Давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөрүүтэй тайлбарлаж хэрэглэсэн гэж дүгнэж, дараах үндэслэлээр эс зөвшөөрч байна.

Шүүгдэгч П.Ундрахын үйлдлийн тухайд:

Шүүгдэгч Пүрэвийн Ундрах /РД:Д376110503/ нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хог тээврийн унаа нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог тус сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/17 дугаартай "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжаар ГААТАСЗДТГ/202201007 дугаартай тендер сонгон шалгаруулалтын үнэлгээний хороо байгуулагдсан байна. Тус үнэлгээний хорооны даргаар П.Ундрах, нарийн бичгийн даргаар Д.Бямба-Очир, гишүүдээр Н.Цэвэлмаа, Д.Оюунбилэг, Ц.Цэвээндулам нарын бүрэлдэхүүнтэй

236

байгуулсан байна. Тус үнэлгээний хороо нь тендер сонгон шалгаруулалтыг эхний удаа нээхэд "Алтайн хишигт өндер" ХХК материал ирүүлсэн байсныг үнэлж 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 03/77 дугаартай албан бичгээр татгалзсан талаар мэдэгдэл хүргүүлсэн байна. Үүний дараа дахин 2 удаа тендер сонгон шалгаруулалтыг зарлахад оролцогч оролцоогүй бөгөөд тендерийн урилгыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зарлахад "Мөнхөд бадрах авто гэр" ХХК материал ирүүлсэн байсныг тус үнэлгээний хороо үнэлж 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 03/147 дугаартай албан бичгээр татгалзсан талаар мэдэгдэл хүргүүлж амжилтгүй болсон байна. Мөн үүний дараа дахин 5 дахь удаагаа тендер сонгон шалгаруулалтыг зарлахад "Олон Улаач" ХХК-иас материал ирүүлсэн байсныг үнэлж 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 03/152 дугаартай албан бичгээр татгалзсан талаар мэдэгдэл хүргүүлсэн байна. Тус сумын Засаг даргын Тамгын газрын дарга П.Ундрах нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг дарга Г.Болормаагаар 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/70 дугаартай "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжийг батлуулан үнэлгээний хороог шинээр байгуулан энэ талаар үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Н.Цэвэлмаа, гишүүн А.Сарантуяа, А.Нансалмаа нарт мэдэгдэлгүйгээр албан ажлаар Тайшир суманд явж байх үед нь үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулж тендер сонгон шалгаруулалтад материал ирүүлсэн өөрийн төрсөн дүү болох П.Тэгшжаргалын хамаарал бүхий "Олон улаач" ХХК-ийг шалгаруулсны дараа 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ГААТАХТУНАГ22/10 дугаартай гэрээг байгуулж, техникийн стандарт үзүүлэлтэд нийцээгүй, өөрийн нөхөр болох Г.Дагвадоржийн нэр дээр итгэмжлэлтэй байсан 19,300,000 төгрөгийн үнэ бүхий автомашиныг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Тайшир сумын Засаг даргын тамгын газарт нийлүүлж өөртөө болон бусдад эдийн засгийн давуу байдал бий болгосон, тус аймгийн Тайшир сумын Орон нутгийн хөгжлийн санд 10.660.000 төгрөгийн хохирол учруулсан нөхцөл байдал хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон.

Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын 2.16 дахь хэсэгт үнэлгээний хороо үйл ажиллагаа явуулах хугацаанд үнэлгээний хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон бол захиалагч түүний хүсэлт, холбогдох баримтыг үндэслэн үнэлгээний хорооны гишүүний үүргээс чөлөөлөх шийдвэр гаргана, 2.18 дахь хэсэгт тендер шалгаруулалт зохион байгуулах хугацаанд үнэлгээний хорооны бүрэлдэхүүн хууль болон энэ журамд заасан шаардлага хангахгүй болсон бол захиалагч шинэ гишүүн нөхөн томилно, 2.24 дэх хэсэг үнэлгээний хорооны анхны бүрэлдэхүүний гуравны нэг ба түүнээс дээш тооны гишүүд ашиг сонирхлын зөрчлийн улмаас үнэлгээний хорооны гишүүний албан үүргээс чөлөөлөгдсөн бол захиалагч үнэлгээний хороог бүхэлд нь шинэчилж, шинэ гишүүдийн бүрэлдэхүүнтэй дахин байгуулах шийдвэрийг гаргана, Мөн ГААТАСЗДТГ/202201007 дугаартай тендер сонгон шалгаруулалт нь нийт 5 удаа зарлагдаж амжилтгүй болсон байхад 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь хэсэг энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах гэснийг тус тус зөрчсөн гэж үзэхээр байна.

Шүүгдэгч П.Ундрах нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хог тээврийн унаа нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог тус сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн

237

А/17 дугаартай "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжаар ГААТАСЗДТГ/202201007 дугаартай тендер сонгон шалгаруулалтын үнэлгээний хорооны даргаар ажиллаж байх явцдаа үндэслэлгүйгээр Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг дарга Г.Болормаагаар 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/70 дугаартай "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжийг батлуулан үнэлгээний хороог шинээр байгуулан энэ талаар үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Н.Цэвэлмаа, гишүүн А.Сарантуяа, А.Нансалмаа нарт мэдэгдэлгүйгээр албан ажлаар Тайшир суманд явж байх үед нь үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулж тендер сонгон шалгаруулалтад материал ирүүлсэн өөрийн төрсөн дүү болох П.Тэгшжаргалын хамаарал бүхий "Олон улаач" ХХК-ийг шалгаруулсан болох нь.

Гэрч Г.Болормаагийн "..миний хувьд бол оруулж ирсэн захирамжийн төсөл дээр нь гарын үсэг зурж баталгаажуулж байсан. Тендер сонгон шалгаруулалттай холбоотой асуудалд би оролцдоггүй тамгын газрын дарга зохион байгуулаад хяналт тавиад ажилладаг байсан. Тайшир сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Ундрах нь "Олон Улаач" ХХК нь Хог тээврийн унаа нийлүүлэх ажил дээр гүйцэтгэгчээр шалгарсан гэрээн дээр нь "Олон улаач" ХХК-ийн захирлын гарын үсгийг нь цахимаар зуруулаад авсан гэж хэлээд надаар гэрээнд гарын үсэг зуруулж баталгаажуулж байсан. Би бол тухайн гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахтай холбоотойгоор "Олон Улаач" ХХК-ийн захирал Н. Төртогтох гэх хүнтэй огт уулзаж байгаагүй, П.Ундрахын халж байснаар бол тухайн хүн нь Улаанбаатар хотод байдаг, гэрээн дээр гарын үсгийг нь цахимаар зуруулж авсан гэж хэлж байсан. Тус "Хог тээврийн унаа нийлүүлэх ажлын гэрээ"-г батлуулахаар П. Ундрах авч орж ирж байсан. "Олон Улаач" ХХК-ийн нийлүүлсэн гэх автомашиныг хүлээж авах комиссыг байгуулж байсан, тухайн комиссыг Засаг даргын тамгын газрын дарга ахалж нийлүүлсэн гэх автомашиныг хүлээж авсан. Тухайн нийлүүлсэн гэх автомашин нь ерөнхийдөө бол анх тавьсан шаардлагыг хангаагүй даац багатай автомашин байсан. П.Ундрахын надад нэг тайлбарлаж байснаар бол "Олон Улаач" ХХК-ийн анх нийлүүлэх гэж байсан автомашины зургийг нь үзүүлж байсан, тэгтэл дараа нь осолд орчихсон нийлүүлэх боломжгүй болсон юм байна, тэгээд солиод одоогийн автомашиныг нийлүүлж байгаа юм байна гэж хэлж байсан. Тухайн автомашиныг нь Улаанбаатар хотоос П.Ундрахын нөхөр нь болох Дагвадорж унаж Говь-Алтай аймгийн Тайшир суманд ирсэн, "Олон Улаач" ХХК-аас бол нийлүүлэхэд захирал нь болон өөр ажилтнууд нь огт ирээгүй. Миний хувьд бол тендер сонгон шалгаруулалтад огт оролцоогүй болохоор нарийн зүйлсийг нь сайн мэдэхгүй байна... Би энэ талаар огт мэдэхгүй байна, ерөнхийдөө бол тухайн тендер сонгон шалгаруулалтыг Засаг даргын тамгын газрын дарга хяналт тавьж явуулж байсан. Засаг даргын тамгын газрын даргын зүгээс шаардлагатай захирамжуудын төслийг нь бэлдээд надаар гарын үсэг зуруулж баталгаажуулдаг байсан. Тэр болгон дээр нь миний бие тендер сонгон шалгаруулалттай холбоотой асуудалд оролцдоггүй байсан юм. 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр А/71 дугаартай захирамжийг гаргахад П.Ундрах төслийг нь бэлтгээд оруулж ирээд надаар гарын үсэг зуруулж байсан, би бол нарийн учрыг нь огт мэдэхгүй байна..." гэх мэдүүлэг,

Г.Болормаагийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр дахин өгсөн "...хог тээврийн унаа нийлүүлэх тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг миний бие сольж байгаагүй, тухайн үнэлгээний хороог байгуулсан захирамжид миний бие гарын үсэг зурж баталгаажуулсан боловч үнэлгээний хороонд томилох албан тушаалтнуудыг миний бие томилж, санал болгож байгаагүй. Гэрээ байгуулах, тендер сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг Тамгын газрын дарга хариуцаж ажилладаг бөгөөд миний бие төсөл бэлтгэж оруулж ирсний нь баталж гарын үсэг зурж ажиллаж байсан... тухайн захирамжийн төслийг П.Ундрах өөрөө боловсруулж байсан юм..." гэх мэдүүлэг,

238

-Гэрч Ч.Оюунгэрэлийн мөрдөн шалгах ажиллагаанд мэдүүлсэн: "... Би 2011 оны 06 сараас хойш 2024 оны 06 дугаар сарыг хүртэл хууль эрх зүйн мэргэжилтнээр томилогдон ажиллаж байсан... Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх худалдан авах ажиллагаатай холбоотой захирамжуудыг Тайшир сумын Засаг даргын тамгын газрын дарга өөрөө боловсруулж гаргадаг байсан юм...би тухайн захирамжийг боловсруулж байгаагүй... Тайшир сумын Засаг даргын тамгын газрын архивын нэгжийг бүрдүүлэхдээ миний зүгээс баримт бичгийн бүрдийг нь хангах зорилгоор дутуу гарын үсгийг нь зурж архивын ажилтанд хүлээлгэж өгдөг байсан бөгөөд тус захирамжид миний бие архивд хүлээлгэж өгөх зорилгоор боловсруулсан хэсэг нь хоосон байсан болохоор нөхөж гарын үсэг зурсан байна..." гэх мэдүүлэг,

-Гэрч А.Доржпагмын мөрдөн шалгах ажиллагаанд мэдүүлсэн: "...зарим тохиолдолд боловсруулсан хүн нь гарын үсэг зураагүй архивын баримтад ирүүлсэн үед нь архивын нэгжийн шаардлагыг хангуулахын тулд хууль, эрх зүйн мэргэжилтнээр нөхөж гарын үсэг зуруулан авдаг тохиолдолд байдаг... Зарим тохиолдолд Тамгын газрын дарга өөрөө тушаал, захирамжийн төслийг боловсруулж гаргадаг.." гэх мэдүүлэг зэргээр шүүгдэгч П.Ундрах нь тус сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/17 дугаартай "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжаар байгуулсан үнэлгээний хорооны гишүүдийн А3 сертификатын эрх дууссан гэх үндэслэлээр үнэлгээний хороог дахин байгуулах захирамжийн төслийг бичиж Тайшир сумын Засаг дарга Г.Болормаагаар 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/70 дугаартай "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжийг батлуулан үнэлгээний хороог шинээр байгуулан энэ талаар үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Н.Цэвэлмаа, гишүүн А.Сарантуяа, А.Нансалмаа нарт мэдэгдэлгүйгээр албан ажлаар Тайшир суманд явж байх үед нь үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулж тендер сонгон шалгаруулалтад материал ирүүлсэн өөрийн төрсөн дүү болох П.Тэгшжаргалын хамаарал бүхий "Олон улаач" ХХК-ийг шалгаруулсан байна.

Шүүгдэгч П.Тэгшжаргалын тухайд:

Шүүгдэгч Олохнууд овогт Пүрэвийн Тэгшжаргал /РД:Д381020609/ нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хог тээврийн унаа нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ГААТАСЗДТГ/202201007 дугаартай тендер сонгон шалгаруулалтад үйл ажиллагаа явуулдаггүй, "Олон Улаач" ХХК-ийн нэрийг ашиглан тендер сонгон шалгаруулалтад оролцон шалгарч улмаар өөрийн төрсөн эгч болох Тайшир сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Ундрахтай "Олон Улаач" ХХК-ийн нэрээр 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ГААТАХТУНАГ22/10 дугаартай гэрээг байгуулж, техникийн стандарт үзүүлэлтэд нийцээгүй, хүргэн ах болох Г.Дагвадоржийн нэр дээр итгэмжлэлтэй байсан 19,300,000 төгрөгийн үнэ бүхий автомашиныг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Тайшир сумын Засаг даргын тамгын газарт нийлүүлсэн, улмаар 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр "Олон Улаач" ХХК-иас 29,960,000 төгрөгийг нэхэмжилсэн нэхэмжлэлийг явуулж "Олон Улаач" ХХК-ийн Хаан банкны 5040275744 дугаарын дансанд 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр 29,960,000 төгрөг орж ирснийг "Олон Улаач" ХХК-ийн дансыг ашиглан өөрийн хамаарал бүхий этгээдүүд болох И.Болормаагийн эзэмшлийн Хаан банкны 5323093006 дугаарын дансанд 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хугацаанд 3 удаагийн гүйлгээгээр 28,150,000 төгрөгийг, мөн П.Тэгшжаргалын эзэмшлийн Хаан банкны 5096008149 дугаарын данс руу 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хугацаанд 4 удаагийн гүйлгээгээр 1,760,000 төгрөгийг, мөн П.Тэгшжаргал нь И.Болормаагийн дансанд шилжиж орсон гэх 28,150,000 төгрөгөөс Д.Маналхишигээр дамжуулан 3,700,000 төгрөгийг шилжүүлэн авснаас П.Ундрахын эзэмшлийн Хаан

239

банкны 5333034616 дугаарын дансанд 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр 1,000,000 төгрөгийг, 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр П.Ганболдын эзэмшлийн Хаан банкны 5336047373 дугаарын дансанд 1,000,000 төгрөгийг тус тус шилжүүлж тус аймгийн Тайшир сумын Орон нутгийн хөгжлийн санд 10,660,000 төгрөгийн хохирол учруулсан гэх гэмт хэргийг хамтран үйлдсэн болох нь хэрэгт авагдсан:

Гэрч Н.Төртогтохын мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн: "...Миний нэр дээр "Олон Улаач" ХХК бүртгэлтэй байдаг... "Олон Улаач" ХХК-ийг П. Тэгшжаргалд ашиглуулахаар болсон юм. Тухайн үед П.Тэгшжаргал нь Говь-Алтай аймгийн Тайшир суманд тендер сонгон шалгаруулалтад орж байгаа юм, аж ахуй нэгж хэрэгтэй байна гэж байхаар нь би өөрийн нэр дээр бүртгэлтэй "Олон Улаач" ХХК-ийн нэрийг нь ашиглахыг зөвшөөрчихсөн юм... Миний хувьд тус тендер сонгон шалгаруулалтын дагуу ямар маркийн автомашин нийлүүлсэн болохыг нь мэдэхгүй байна, энэ талаар П.Тэгшжаргал мэдэж байгаа, миний хувьд тус асуудалд огт оролцоогүй. 2022 оны сүүлээр тендерт шалгараад машинаа хүлээлгэж өгсөн гэтэл тухайн машин нь эвдрэлтэй буюу турбо нь ажиллахгүй байсан, тэгээд сэлбэгийг нь Улаанбаатар хотоос аваад Тайшир суманд аваачиж өгөөд засуулаад өгсөн гэж П.Тэгшжаргал сүүлд нь ярьж байсан..." гэх мэдүүлэг,

2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр дахин мэдүүлсэн: "...Тайшир сумаас зарлаж явуулсан гэх хог тээврийн унаа нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ГААТАСЗДТГ/202201007 дугаартай тендер сонгон шалгаруулалтын талаар хамгийн анх бол мэдээгүй... Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ундрах гэж хүний төрсөн дүү Тэгшжаргал нь надтай утсаар холбогдоод тендерт оролцох гэсэн юм компани хэрэгтэй байна гэхээр нь би тус болох үүднээс хандсан... Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ундрах гэж хүний төрсөн дүү Тэгшжаргал нь тендерт оролцох гэсэн юм гэж байсан... Тэрнээс надад нарийвчлан хог тээврийн унаа нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер сонгон шалгаруулалтад материал хүргүүлж байгаа талаар хэлээгүй... Нэг удаа Ундрах утсаар холбогдоод баримт бичиг явуулна гарын үсэг тамга дараад өгөөрэй гэхээр нь хүлээн авч гарын үсэг тамга дарж явуулж байсан..." гэх мэдүүлэг,

- Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/71 дугаартай "Гэрээ байгуулах эрх олгох тухай" захирамжийн хуулбар,

- Гэрч Н.Цэвэлмаагийн мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн: "... Үнэлгээний хороог яагаад ямар шалтгааны улмаас шинээр байгуулаад намайг нарийн бичгийн даргаар томилсон болохыг нь би мэдэхгүй байна... 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр А/70 дугаартай захирамжаар үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар томилсон байсан. 2022 оны 05 дугаар сарын үед Орон нутгийн өмчийн газраас сумуудаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажилтай Б.Нансалмаа, А.Сарантуяа нарын хамт сумуудаар явж ажиллаж байсан юм.... Үнэлгээний хорооны хуралд Ц. Цэвээндулам бол оролцож байсан, Тайшир суманд 2022 оны 05 дугаар сард Б. Нансалмаа, А. Сарантуяа бид нар ажиллаж явж байхдаа үнэлгээний хорооны хуралд оролцож байсан, энэ үед Ц.Цэвээндулам нь оролцож байсан. Харин Ц.Эрдэмбилэг нь бол цахимаар болон биечлэн үнэлгээний хорооны хуралд оролцож байгаагүй... гэх мэдүүлэг,

- Гэрч А.Сарантуяагийн мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн: "... Би Тайшир суманд зохион байгуулагдсан хог тээврийн унаа нийлүүлэх тендер сонгон шалгаруулалттай холбоотойгоор үнэлгээний хороонд томилогдож байсан гэдгээ мэдээгүй явж байгаад 2022 оны 05 дугаар сарын сүүлээр Тайшир суманд орон нутгийн өмчийн тооллогоор томилолтоор явж байгаад анх мэдэж байсан... Ямартай ч Н.Цэвэлмаа эгчтэй хамт тус хуралд оролцсон гэдгийг бол санаад байна..." гэх мэдүүлэг,

240

- Гэрч Г.Болормаагийн мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн: "... Тайшир сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Ундрах нь "Олон Улаач" ХХК нь Хог тээврийн унаа нийлүүлэх ажил дээр гүйцэтгэгчээр шалгарсан гэрээ дээр нь Олон улаач ХХК-ийн захирлын гарын үсгийг нь цахимаар зуруулаад авсан гэж хэлээд надаар гэрээнд гарын үсэг зуруулж баталгаажуулж байсан. Би бол тухайн гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахтай холбоотойгоор "Олон Улаач" ХХК-ийн захирал Н.Төртогтох гэх хүнтэй огт уулзаж байгаагүй, П.Ундрахын хэлж байснаар бол тухайн хүн нь Улаанбаатар хотод байдаг, гэрээн дээр гарын үсгийг нь цахимаар зуруулж авсан гэж хэлж байсан. Тус "Хог тээврийн унаа нийлүүлэх ажлын гараа"-г батлуулахаар П.Ундрах авч орж ирж байсан. "Олон Улаач" ХХК-ийн нийлүүлсэн гэх автомашиныг хүлээж авах комиссыг байгуулж байсан, тухайн комиссыг Засаг даргын тамгын газрын дарга ахалж нийлүүлсэн гэх автомашиныг хүлээж авсан..." гэх мэдүүлэг,

- Гэрч Ц.Эрдэмбилэгийн мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн: "...Би тухайн тендер сонгон шалгаруулалтад огт оролцоогүй, мөн үнэлгээний хорооны гишүүнээр албан ёсоор томилогдсон гэдгийг мэдээгүй байсан. Үнэлгээний хороонд оролцоогүй болохоор юу ч мэдэхгүй байна..." гэх мэдүүлэг,

- Гэрч Н.Цэвэлмаагийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр өгсөн: ".. Үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулах үед тендер сонгон шалгаруулалтад нэг оролцогч материал ирүүлсэн байсан бөгөөд оролцогчийн материалыг нь үнэлж үзэхэд шаардлага нийцэж байсан тул захиалагчид зөвлөмж бичиж хүргүүлж байсан... Үнэлгээний хорооны гишүүдэд ямар нэгэн байдлаар "Олон улаач" ХХК-ийг сонгон шалгаруулж өгөх талаар хэн нэгэн албан тушаалтнаас хэлж байсан зүйл байхгүй...тус захирамжийг Тайшир сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Ундрах танилцуулж байсан..." гэх мэдүүлэг,

- Гэрч Б.Нансалмаагийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр өгсөн: "... Үнэлгээний хорооны хурлаар "Олон улаач" ХХК-ийн ирүүлсэн материалыг нь үнэлж үзээд шаардлагуудыг хангаж байна гэж үзээд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлэх болсон..." гэх мэдүүлэг,

- 2025 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Хог тээврийн унаа нийлүүлэх барааны тендерийн баримт бичигт үзлэг хийсэн мөрдөгчийн тэмдэглэл,

- Гэрч Г.Цогбадрахын мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн: "...Миний бие 2019 ОНООС 2023 оныг хүртэл хувиараа Да хүрээ зах дээр автомашин худалдаж борлуулдаг байсан юм. Одоогийн байдлаар бол эрхэлсэн тодорхой ажилгүй байна. Миний бие тухайн цаг хугацаанд автомашин худалдаж борлуулдаг байсан юм. Ихэвчлэн портер, бонго гэх маркийн автомашинуудыг худалдаж борлуулдаг байсан юм. Тухайн 2022 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 2464 дугаартай итгэмжлэл нь Г.Дагвадорж гэх хүнд автомашин худалдаж борлуулаад өөрийнхөө нэр дээр тухайн хүн дээр итгэмжлэл хийж өгч байсан юм байна... Тэгээд наймаа хийсний маргааш нь над руу яриад Лүн өнгөрч явна энэ машины ус нь халаад явахгүй байна гэж байсан, тэгээд орой нь Баянхонгор орчихлоо гэж ярьсан бөгөөд энэ үед мөн машин чинь эвдрээд байна, засвар үйлчилгээ хийлгээд их зардал гарлаа гэж байхаар нь миний бие 1,000,000 гаруй төгрөгийг тус ярьсан гэх хүний данс руу нь шилжүүлж өгч байсан юм. Энэ нь дансны хуулгаар харагдана, тухайн үеийн дансны хуулгыг гаргаж өгч болно... Тухайн автомашины хувьд бол бүрэн бүтэн автомашин байсан, харин худалдаж авсан гэх Г.Дагвадорж нь над руу яриад замд явж байна машины чинь ус нь халаад эвдрээд явахгүй байна, засвар хийлгээд их зардал гарлаа гэж ярьж байсан бөгөөд миний бие 1,000,000 гаруй төгрөгийг засвар үйлчилгээний мөнгө гэж дансаар шилжүүлж өгч байсан. Тухайн автомашин нь Монгол Улсад 2022 онд орж ирсэн, анх Бүгд Найрамдах Солонгос Улсаас захиж худалдаж авсан машин байсан..." гэх мэдүүлэг,

- Гэрч Д.Маналхишигийн мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн: "... Тухайн машиныг хэн гэдэг хүнээс худалдаж авсан талаараа бол мэдэхгүй байна. Миний худалдаж авсан машин одоо хаана байгааг санахгүй байна. Би өөрөө бол авч ашиглаагүй худалдаж аваад бусдад худалдсан... Г.Цогбадрахад шилжүүлсэн гэх 19,300,000 төгрөг бол миний мөнгө бол биш байсан. Би И.Болормаагаас 19,300,000 төгрөг зээлж авч байсан. И.Болормаа уг мөнгийг хаанаас хэнээс авсан мөнгө гэдгийг бол мэдэхгүй... Манай ээжийг Пүрэвийн Алтанцэцэг гэдэг бөгөөд П.Ундрах нь манай ээжийн төрсөн дүү юм. Г.Дагвадорж бол П.Ундрах эгчийн нөхөр нь юм. П.Ундрах эгч болон түүний нөхөр Г.Дагвадорж нарыг багаасаа танина. Гэхдээ бол хамт амьдардаггүй..." гэх мэдүүлэг,

- Шүүгдэгч П.Тэгшжаргалын шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн: "... Би Маналхишиг гээд манай дүү чинь авто тээврийн инженер хүн байхгүй юу. Би дүүгээ явуулж авхуулсан... Машиныг авхуулаад нааш нь явуулах болсон чинь эд нар жолоочоо явуулж чадахгүй гэж ярьсан гэхээр нь хүн олж явуулах болсон. Тухайн үед манай хүргэн ах Улаанбаатарт явж байсан учраас тэр хүн дээр нь дагуулж очоод шууд Дагвадоржийн нэрээр итгэмжлэл хийж явуулъя гэж гуйгаад зөвшөөрөхөөр нь дагуулж очиж итгэмжлэлийг нь хийлгэсэн..." гэх мэдүүлэг,

- 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр гэрч Д.Маналхишигийн эзэмшлийн Хаан банкны 5315621197 дугаарын дансны хуулганд үзлэг хийсэн тэмдэглэл,

-2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Хаан банк ХХК-иас 392 дугаартай албан бичгээр ирүүлсэн Г.Цогбадрахын эзэмшлийн 5307204296 тоот харилцах дансны хуулга, Г.Давгадоржийн эзэмшлийн 5333010617 тоот харилцах дансны хуулга,

- Гэрч Г.Цогбадрахын мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн: "... Тухайн 2022 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 2464 дугаартай итгэмжлэл нь Г.Дагвадорж гэх хүнд автомашин худалдаж борлуулаад өөрийнхөө нэр дээр тухайн хүн дээр итгэмжлэл хийж өгч байсан юм байна. Үүнээс өөрөөр Гэрэлийн Дагвадорж гэх хүнийг би танихгүй... Тэгээд наймаа хийсний маргааш нь над руу яриад Лүн өнгөрч явна энэ машины ус нь халаад явахгүй байна гэж байсан, тэгээд орой нь Баянхонгор орчихлоо гэж ярьсан бөгөөд энэ үед мөн машин чинь эвдрээд байна, засвар үйлчилгээ хийлгээд их зардал гарлаа гэж байхаар нь миний бие 1,000,000 гаруй төгрөгийг тус ярьсан гэх хүний данс руу нь шилжүүлж өгч байсан юм. Энэ нь дансны хуулгаар харагдана, харин худалдаж авсан гэх Г.Дагвадорж нь над руу яриад замд явж байна машины чинь ус нь халаад эвдрээд явахгүй байна, засвар хийлгээд их зардал гарлаа гэж ярьж байсан бөгөөд миний бие 1,000,000 гаруй төгрөгийг засвар үйлчилгээний мөнгө гэж дансаар шилжүүлж өгч байсан. Тухайн автомашин нь Монгол Улсад 2022 онд орж ирсэн, анх Бүгд Найрамдах Солонгос Улсаас захиж худалдаж авсан машин байсан..." гэх мэдүүлэг,

- 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Хаан банк ХХК-иас 392 дугаартай албан бичгээр ирүүлсэн Г.Цогбадрахын эзэмшлийн 5307204296 тоот харилцах дансны хуулга, Г.Давгадоржийн эзэмшлийн 5333010617 тоот харилцах дансны хуулга,

- Шүүгдэгч П.Тэгшжаргалын шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн: "...Машиныг авхуулаад нааш нь явуулах болсон чинь эд нар жолоочоо явуулж чадахгүй гэж ярьсан гэхээр нь хүн олж явуулах болсон. Тухайн үед манай хүргэн ах Улаанбаатарт явж байсан учраас тэр хүн дээр нь дагуулж очоод шууд Дагвадоржийн нэрээр итгэмжлэл хийж явуулъя гэж гуйгаад зөвшөөрөхөөр нь дагуулж очиж итгэмжлэлийг нь хийлгэсэн..." гэх мэдүүлэг зэрэг нотлох баримтаар нь шүүгдэгч П.Тэгшжаргал нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хог тээврийн унаа нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ГААТАСЗДТГ/202201007, дугаартай тендер сонгон шалгаруулалтад үйл ажиллагаа явуулдаггүй, "Олон Улаач" ХХК-ийн нэрийг

241

ашиглан тендер сонгон шалгаруулалтад оролцон шалгарч улмаар өөрийн төрсөн эгч болох Тайшир сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Ундрахтай "Олон Улаач" ХХК-ийн нэрээр 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ГААТАХТУНАГ22/10 дугаартай гэрээг байгуулж хүргэн ах болох Г.Дагвадоржийн нэр дээр итгэмжлэлтэй байсан 19,300,000 төгрөгийн үнэ бүхий автомашиныг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Тайшир сумын Засаг даргын тамгын газарт нийлүүлсэн, улмаар 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр "Олон Улаач" ХХК-иас 29,960,000 төгрөгийг нэхэмжилсэн нэхэмжлэлийг явуулж "Олон Улаач" ХХК-ийн Хаан банкны 5040275744 дугаарын дансанд 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр 29,960,000 төгрөг орж ирснийг "Олон Улаач" ХХК-ийн дансыг ашиглан өөрийн хамаарал бүхий этгээдүүд болох И.Болормаагийн эзэмшлийн Хаан банкны 5323093006 дугаарын дансанд 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хугацаанд 3 удаагийн гүйлгээгээр 28,150,000 төгрөгийг, мөн П.Тэгшжаргалын эзэмшлийн Хаан банкны 5096008149 дугаарын данс руу 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хугацаанд 4 удаагийн гүйлгээгээр 1,760,000 төгрөгийг, мөн П.Тэгшжаргал нь И.Болормаагийн дансанд шилжиж орсон гэх 28,150,000 төгрөгөөс Д.Маналхишигээр дамжуулан 3,700,000 төгрөгийг шилжүүлэн авснаас П.Ундрахын эзэмшлийн Хаан банкны 5333034616 дугаарын дансанд 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр 1,000,000 төгрөгийг, 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдөр П.Ганболдын эзэмшлийн Хаан банкны 5336047373 дугаарын дансанд 1,000,000 төгрөгийг тус тус шилжүүлж тус аймгийн Тайшир сумын Орон нутгийн хөгжлийн санд 10,660,000 төгрөгийн хохирол учруулсан гэх гэмт хэргийг хамтран үйлдсэн гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдож байна.

Шүүх аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ хууль ёсны дагуу явагдсан эсэх, уг ажиллагааг явуулахад Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуулийн заалтыг чанд мөрдөгдсөн эсэхийг хянан үзэж, хуулиар хамгаалагдсан бусдын зөрчигдсөн эрхийг сэргээж, гэм буруутай этгээдэд шударгаар ял шийтгэл оногдуулах учиртай.

Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, шүүгдэгч П.Ундрах, П.Тэгшжаргал нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж шийдвэрлэсэн нь хэргийн бодит байдалтай нийцээгүй, үндэслэлгүй шийдвэр гаргасан гэж дүгнэж байна.

Иймд Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Говь-Алтай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2026 оны 07 сарын 06-ны өдрийн 2026/ДШМ/17 дугаартай магадлалыг хүчингүй болгуулж, Говь-Алтай аймаг дахь Сум дундын анхан шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 2026/ШЦТ/63 дугаартай шийтгэх тогтоолыг хэвээр үлдээлгэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан прокурорын эсэргүүцэл бичив.

АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ХЯНАЛТЫН ПРОКУРОР,
ХУУЛЬ ЦААЗЫН ДЭД ЗӨВЛӨХ Ө.МАНЗУШИР